



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/312

Булган сум

Захирамжинд өөрчлөлт оруулах тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 23 дугаар зүйлийн 23.3.7, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/461 дүгээр захирамжийн 2.2 дахь хавсралтаар баталсан 2 дугаар байршил (Онгоцны буудлын урд дэнж), 2.5 дахь хавсралтаар баталсан 5 дугаар байршил (1 дүгээр Хатанбаатар Магсаржавын бунхны хэсэг), 2.6 дахь хавсралтаар баталсан 6 дугаар байршил (1 дүгээр баг Цэнгэлдэхийн хэсэг), 2.7 дахь хавсралтаар баталсан 7 дугаар байршил (1 дүгээр баг Нөөцийн хэсэг)-ийн байршлуудыг хассугай.

2. Хасагдсан байршлуудад газрын эрх зүйн харилцаа, үүссэн нэгж талбарын хувийн хэргийг Булган суманд шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж хамтран ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Булган сумын Зааг дарга (П.Нөхөрлөлбаяр) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

